



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2023 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 140

Өлгий сум

“Нээлттэй -Баян-Өлгий” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус арван гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хот болон төв суурин газраас Баян-Өлгий аймагт шилжин ирж суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, аймгийн ард иргэдийг тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилго бүхий “Нээлттэй – Баян-Өлгий” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Төлөөлөгчдийн саналыг тусгаж “Нээлттэй – Баян-Өлгий” хөтөлбөрийг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х.Арман)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Хот суурин, дэд бүтцийн хөгжлийн хороо (С.Есболат), Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороо (Х.Нурка) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Ш.ХАВЫЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2023 оны 03 дугаар сарын 14 ны өдрийн  
ээлжит бус арван гуравдугаар хуралдааны  
140 дугаар тогтоолын хавсралт

## **“НЭЭЛТТЭЙ БАЯН-ӨЛГИЙ” ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Үндсэн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьшин ажиллаж амьдрах, иргэд, ААН, байгууллагыг угтан авахад шаардагдах бэлтгэлийг хангах, аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, аймаг орон нутгийн талаарх нэгдсэн ойлголт, мэдээллийн нэгдмэл удирдлага, зохицуулалтыг бий болгож цахимжуулах, төрийн үйлчилгээг ойлгомжтой, шуурхай болгох, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 419 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх замаар аймаг, сум орон нутгаа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **Хоёр. Зорилгыг хэрэгжүүлэх зорилтууд:**

**Зорилт 1. Аймаг, орон нутгийн төр, захиргааны байгууллагуудаас холбогдох тооцоо судалгааг гаргуулж, төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах.**

2.1.1. Улаанбаатараас болон бусад суурин газраас аймагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгжийн тоог нэмэгдүүлэх талаар шинээр батлагдах нэмэлт өөрчлөлт орох хууль тогтоомжийн төсөлд холбогдох байгууллага, иргэдийн саналыг хүргүүлнэ.

2.1.2. Төрийн үйлчилгээг цахим болгох, цахим системийн хэрэглээг нэмэгдүүлэн, орон нутагт шинээр бий болох ажлын байрны мэдээллийг “Bayan-Olgii.gov.mn” болон “E-Mongolia” системд байрлуулах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

2.1.3 Аймагт шилжин ирсэн иргэд болон хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй иргэдийг байнгын ажлын байраар хангасан аж ахуйн нэгжийг урамшуулах, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хүний нөөц, татварын орлогыг аймагтаа шилжүүлэх эрх зүйн үндэслэлийг орон нутгийн түвшинд боловсруулж хэрэгжүүлнэ.

**Зорилт 2. Аймгийн хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнесийг дэмжсэн эдийн засгийн есөлтийг бий болгох тэргүүлэх чиглэлийн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг дэмжинэ.**

2.2.1 Аймагт малчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагааны түншлэлийн хүрээнд дэвшилтэт техник, технологи бүхий арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үр ашгийг нь малчид, үйлдвэрлэгчид хүртдэг тогтолцоог бүрдүүлнэ.

2.2.2 Шилжин ирэгсдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хоршоо хөгжүүлэх сан болон олон улсын төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр иргэд, аж ахуйн нэгжид ажлын байрны хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулах арга хэмжээг авна.

2.2.3. Даян боомтын үйл ажиллагааг сэргээж, тухайн чиглэлийн зам, тээвэр логистикийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.

2.2.4. Цагааннуур чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.2.5. Услалтын системийг түшиглэн газар тариалан эрхлэх боломжтой газрыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгохын зэрэгцээ жимс, жимсгэнийн болон хүлэмжийн аж ахуй эрхлэх иргэдэд хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээ үзүүлнэ.

2.2.6 Услалтын системийг түшиглэн газар тариалан эрхлэх боломжтой газрыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд олгохын зэрэгцээ газар тариалан эрхлэх хүсэлтэй иргэдэд хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.

2.2.7. Тариалангийн талбайг хашаажуулах, ойн зурвас байгуулах, хөрсийг салхи, усны элэгдэл, эвдрэл, мал амьтны талхигдлаас хамгаалахад төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.2.8. Аялал жуулчлалын бүсэд эрчим хүч, дэд бүтцийг шийдвэрлэн жуулчдын аялах таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.9. Эко аялал жуулчлалын орчныг бүрдүүлэн аялал жуулчлалын бүсүүдэд отоглох, хоноглох цэгийг байгуулж, хяналтыг сайжруулна.

2.2.10. Аймгийн онцлог, түүх, өв соёл, орон нутагт байгаа боломж, нутгийн брэндээ ард иргэдэд таниулах, эдийн засгийн хувьд бие даах, аймаг орон нутгаа хөгжүүлэх боломжийг бий болгоно.

2.2.11. Сургууль, цэцэрлэгийн тохижилт, хүүхдийн тоглоомын талбайн тоог нэмэгдүүлж, хүүхэд багачуудын хөгжих орчны стандартын шаардлагыг бүрэн хангуулна.

2.2.12. Өлгий хотын төвд стандартад нийцсэн явган хүний зам, гарц, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг болон гудамж талбайн тохижилтын ажлыг цогцоор нь шинэчилнэ.

2.2.13. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн болон бусад байгууллагаас хэрэгцээт үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.14. Инженерийн шугам сүлжээ буюу дулаан, цэвэр ус, цэвэрлэх байгууламжийн хоёр дахь эх үүсвэрийг барьж байгуулснаар агаарын бохирдол буурч, иргэдийн эрүүл, цэвэр орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ.

2.2.15. Сум, багуудад гүний худаг гаргах, Өлгий хотын төвийн оршин суугчдын цэвэр усны хангамжийг үе шаттайгаар нэмэгдүүлснээр иргэдийн ундны усны асуудал шийдвэрлэгдэнэ.

2.2.16. Өлгий хотын төвийн багуудыг дахин төлөвлөлтөд оруулан дэд бүтцийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлснээр иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдэнэ.

2.2.17. Найдвартай цахилгаан эрчим хүчээр хангана.

2.2.18. Шинээр олгох газрын төлөвлөгөө хийж, шилжин суурьшигчдыг газраар бүрэн хангана.

2.2.19. Аймгийн төвийн 900 айлын орон сууцны хорооллын гадна дулааны шугам 1800 м урт, гадна бохир усны 2800 м урт шугамыг тус тус улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж, дуусган шилжин ирэгсдийг орон сууцаар хангах боломж бүрдүүлнэ.

2.2.20. Аймгийн төвд байгаа ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай 7 орон сууцыг буулган шинээр барих замаар шилжин ирэгсэд болон зорилтот бүлгүүдийг орон сууцаар хангах нөхцөл бүрдүүлнэ.

### **Зорилт 3. Байгалийн нөөцийг нэмэгдүүлж, орчны бохирдлыг бууруулах бодлогыг орон нутагт хэрэгжүүлж, хүрээлэн буй орчныг сайжруулна.**

2.3.1. Аймгийн хэмжээнд мод тарих ажлыг эрчимжүүлэх, шинээр ногоон байгууламжийн бүс байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.2. Ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулна.

2.3.3. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийлгэнэ.

2.3.4. Уур амьсгалын өөрчлөлтөд дорвитой хувь нэмэр оруулан "20 сая мод" аянд идэвхтэй оролцож, мод тарьсан, ногоон зурвас байгуулсан оролцогч иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн үйл ажиллагааг орон нутгаас дэмжиж хамтран ажиллана.

### **Зорилт 4 Аймгийн хүн амын хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлогыг нэмэгдүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.**

2.4.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, ажлын байр нэмэгдүүлсэн нийгмийн хариуцлагатай ажил олгогч иргэн, компанийг шалгаруулах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

2.4.2. Шинээр ажлын байрыг бий болгох арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд тулгамдаж буй асуудал болон ажилгүй иргэдийг ажлын байртай болгох зорилгоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

2.4.3. Халамжаас – хөдөлмөрт арга хэмжээг эрчимжүүлнэ.

### **Зорилт 5 Аймгийн боловсрол, эрүүл мэндийн салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.**

2.5.1. Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг аймгийн хэмжээнд нэмэгдүүлж, удирдлагын арга барил, үйлчилгээний чанарыг сайжруулан, хүүхдийн авьяасыг илрүүлэн хөгжүүлнэ.

2.5.2. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагын арга барилыг шинэчилж, сургалтын чанарыг ахиулан, чанарын үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэн, ЭЕШ-ын дүнгээр улсын хэмжээнд эзлэх байрыг тогтмол урагшлуулна.

2.5.3. Бүх шатны сургалтын байгууллагын менежментийг сайжруулах шилдэг туршлагыг судалж, нэвтрүүлнэ.

2.5.4. Багш сонгон шалгаруулах үйл явцыг шударгаар, нээлттэй, зохион байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

2.5.5. Сургууль, цэцэрлэгт сурч боловсрох ээлтэй орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, шаардлагатай сургууль, дотуур байр, цэцэрлэгийг шинээр барих, тусгай хэрэгцээт хүүхдийг, тусгай хэрэгцээт хүүхдийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5.6. Эмнэлгийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргаж, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шилдэг менежментийг нэвтрүүлнэ.

2.5.7. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах, аймагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

2.5.8. Эрүүл мэндийн яаралтай тусламжийн чанар, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

2.5.9. Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, бусад салбарын оролцоог нэмэгдүүлэн эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

### **Зорилт 6. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, оролцоог дэмжиж ажиллана.**

2.6.1. Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг байгуулан, үүгээр дамжуулан шилжин суурьших гэр бүлүүдэд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлнэ.

#### **Гурав. Үр дүн**

"Нээлттэй Баян-Өлгий" арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

3.1. Шилжин ирэгсдийн тоо нэмэгдсэн байна.

3.2. Орон нутагтаа оршин суугч болон шилжин ирэгч иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцөл сайжирсан байна.

3.3. Шинэ ажлын байр нэмэгдсэн байна.

3.4. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх болон үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.

#### **Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

4.1. Хөтөлбөрийн эхний үе шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

#### **Тав. Санхүүжилтийн эх үүсвэр**

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх

үүсвэрээр бүрдүүлнэ:

- 5.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө
- 5.1.2. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт
- 5.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө
- 5.1.4. Бусад эх үүсвэр

### **Зургаа. Хяналт шинжилгээ, үнэлгээ**

6.1.1 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь арга хэмжээний бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

6.2.1 Арга хэмжээний хэрэгжилтийн явцад хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох үзүүлэлтэд хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно